



МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 347

Улаанбаатар хот

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2013 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн өмчийн хорооны 2010 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг тэнцвэржүүлсэн үнэлгээний аргаар дүгнэх, урамшуулал олгох журам”-ын 3 дугаар бүлгийн 4, 5, 6, 9, 10 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2013 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний биелэлтийг “сайн” гэж дүгнэсүгэй.
2. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал Ж.Солонгод 2013 оны ажлын үр дүнгээр 3,352,960 /гурван сая гурван зуун тавин хоёр мянга есөн зуун жаран/ төгрөгийн урамшуулал олгосугай.
3. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал Ж.Солонгод олгох урамшууллыг зохих эх үүсвэрээс гаргахыг компанийн ерөнхий санхүүчид зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлагын газар /Д.Болормаа/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Д.ЦОГТБААТАР

Ц.ОДМАА

Ц.ОДМАА

0001298